

Петро Матад Лимитед (“Петро Матад” “Компани”)

Хайгуулын Менежер томилох тухай

Петро Матад компани та бүхэнд Доктор Жэймс Күүган-ыг Хайгуулын Менежер албан тушаалд томилон тус компанийн ахлах удирдлагын багтаа оруулж байгаага мэдэгдэхэд баяртай байна. Доктор Жэймс Күүган бол газрын тосны геологч бөгөөд тус салбарын, улсын болон бусад сургалтын байгууллагуудад ажилласан 28 жилийн туршлагатай хүн юм. Уг туршлагаа АНУ улсад болон олон улсын түвшинд ажиллаж олж авсан бөгөөд АНУ, Хойд Африк болон Өмнөд Америкт гаргасан нээлтүүдийг оролцуулан уул уурхайн хайгуул, өрөмдлөгө, маркетингийн бүхий л чиглэлээр техникийн удирдлагаар ханган ажиллаж байсан билээ.

Доктор Күүган нь Петро Матадын үйл ажиллагаа явуулж буй Төв Азийн сав газруудтай ижил төстэй геологийн тогтоц бүхий газруудад ажиллаж байсан олон жилийн туршлагатай нэгэн юм. Тэрээр томоохон олон улын газрын тосны компаниудад ажиллахаас гадна_ жижигхэн төрөлжсөн хайгуулын болон боловсруулалтын компаниудад мөн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг болон эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудад ч ажиллаж байсан хүн юм.

Сүүлийн 8 жилийн хугацаанд доктор Күүган нь Колорадогийн Вестрен Стейт Коллеж /Western State College of Colorado/-д газрын тосны геологийн факультетын захирлаар ажиллаж байсан бөгөөд тэнд байхдаа Газрын Тосны Геологийн Хөтөлбөр үүсгэн байгуулсан нэгэн юм. Энэхүү ажлыг эрхэлж байхдаа тэрээр газрын тосны салбарын стандарт технологийг, геологийн шинжлэх ухаан болон бизнесийн боловсролтой хослуулах байдлаар тус коллежийн Мэргэжлийн Газар болон Нөөц Баялагийн Менежментийн сургалтын хөтөлбөрийг зохиоход гар бие оролцсон юм. Түүний хажуугаар доктор Күүган нь Эксон Мобил Корпораци /ExxonMobil Corp/, Анадарко Петролиум Компани /Anadarko Petroleum Co/, Самсон Ресурсес Компани /Samson Resources Co/, Талисман Энержи Инк /Talisman Energy Inc/, Ансбро Петролиум Компани /Ansbro Petroleum Co/ болон бусад компаниудын шугмаар томоохон даалгаврууд гүйцэтгэж байжээ. Түүний урьд өмнө хийж байсан ажлууд гэвэл Сохио Петролиум Компани /Sohio Petroleum Co/, Ю Эс Мобил Эксплорэйшн энд Продакшин, Аншүтз Эксплорэйшн Корпорацид /Mobil Exploration and Production U.S., Anschutz Exploration Corp/, ажиллаж мөн үндэсний ба олон улсын янз бүрийн үйлчлүүлэгчдэд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг өөрийн хувийн зөвлөх компанийг 6 жил удирдаж байсан юм.

Одоо Петро Матад компанийн Техникийн хэлтсийн дарга Род Грахам болон доктор Күүган нар олон улсын болон Монголын мэргэжилтнүүдийг элсүүлэн авч тус компанийн өөрийн гэсэн хайгуулын багийг бүрдүүлэх ажлыг хийж гүйцэтгэж байна. Тус компанийн бизнес төлөвлөгөөнд хайгуулын мэргэжилтнүүдийн цомхон хэмжээтэй өөрийн чадалтай баг бүрдүүлэн Матад ХХ талбайн нарийвчилсан хайгуул болон Петро Матадын судалгаа бага хийгдсэн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээт хайгуулын IV болон V талбайнууд дээр хайгуул явуулах ажил багтсан болно. Доктор Күүган болон бусад гэрээт олон улсын мэргэжилтнүүд нь Род Грахамын удирдан ажиллаж байгаа Улаанбаатарт байрладаг Монгол дахь Техникийн Хэлтэсийн багт удахгүй байнга ажиллах болно.

Компанийн Ерөнхий захирал Дуглас МакГей хэлэхдээ “Бид доктор Күүганыг Петро Матадын багт тавтай морилохыг хүсч байна. Түүний мэргэжлийн ур чадвар, туршлага болон хувь хүний зан чанар нь манай компани болон газрын тосны хайгуулын ажилд маш сайн тохирох учраас түүнийг энэ ажилд томилож байгаадаа баяртай байна. Түүний гол анхааран ажиллах зүйл бол энэхүү хайгуулын багийг удирдах, манай компанийг техникийн амжилтанд хүргэхэд гол мэдлэг чадвараа ашиглах явдал бөгөөд компаний эрхэм зорилгыг хэрэгжүүлэн Монголын газрын тосны мэргэжилтнүүдэд зохих ёсны технологийн мэдлэг суулгах зорилгод өөрийн салбарын болон сургалтын мэдлэг туршлагаа зориулах явдал юм” гэсэн билээ.

Редакторт өгөх санамж:

Петро Матад Лимитед компаний тухай

Петро Матад Лимитед бол Монголд газрын тосны хайгуул болон ирээдүйн олборлолт үйлдвэрлэл явуулах группын эцэг компани нь юм. Тус Групп нь Монгол улсын Засгийн газартай Бүтээгдхүүн Хуваах гурван Гэрээнүүд байгуулан дангаараа ажиллаж байгаа гүйцэтгэгч юм. Компанийн гол хөрөнгө нь тус улсын алс дорнодод 14,250 хавтгай дөрвөлжин километр талбайтай Бүтээгдхүүн Хуваах Гэрээт Матад ХХ талбай юм. Бусад IV болон V талбай нь Монгол улсын төв хэсэгт орших бөгөөд хамтдаа нийлээд 73498 хавтгай дөрвөлжин километр квадрат талбайг хамардаг юм.

Петро Матад Лимитэд нь Айлсе оф Майн /Isle of Man/-ын улсад байгуулагдсан, 1483В дугаарын бүртгэлтэй компани юм. Компанийн албан ёсны бүртгэлтэй байр нь Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ -т байрладаг юм.

Мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харьцаж болно:

Petro Matad Limited
Douglas J. McGay - CEO
+976 11 331099

Westhouse Securities Limited
Richard Baty/Petre Norton
+44 (0)20 7601 6100

Bankside Consultants
Simon Rothschild / Oliver Winters / Louise Mason
+44 (0)20 7367 8888